



САНГИЙН ЯАМ

ИРГЭДИЙН ТӨСӨВ 2020

МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН
ТӨСВИЙН ТӨСӨЛ





САНГИЙН ЯАМ



Монгол Улсын Сангийн яамны санаачилгаар, Европын холбооны буцалтгүй тусламжийн хүрээнд Дэлхийн банкны хэрэгжүүлж буй Монгол Улсад Засаглалыг бэхжүүлэх төслийн санхүүжилтээр энэхүү “Иргэдийн төсөв - 2020” товхимлыг бэлтгэн гаргав.

Уг товхимлыг арилжааны бус зорилгоор бүрэн болон хэсэгчилсэн байдлаар ашиглаж болох бөгөөд ашигласан тохиолдолд “Иргэдийн төсөв-2020, Монгол Улсын нэгдсэн төсвийн төсөл”, Сангийн яам хэмээн эх сурвалж хэсэгт тодотгоно уу.

Санал хүсэлт болон агуулгатай холбоотой лавлах зүйл байвал Сангийн яамны tusuv@mof.gov.mn цахим шууданд ирүүлнэ үү.

МЭНДЧИЛГЭЭ

Төсөв бол тухайн улс орны оршин тогтнох эдийн засгийн үндсийг бүрдүүлэх, төрөөс нийгмийн, ард иргэдийн сайн сайхны төлөө зарцуулах хөрөнгийн эх үүсвэр юм.

Монгол Улсын төсөв нь татвар төлөгч иргэн таны, аж ахуйн нэгж байгууллагын хөдөлмөрийн үр шимээс бүрддэг учраас юунд зарцуулж ямар үр дүнд хүрсэн талаар нээлттэй мэдээлэл өгч, цаашлаад иргэдийн оролцоог дэмжих нь бидний үүрэг билээ.

Сангийн яамны санаачилгаар төсвийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, иргэдийн төсвийн тухай мэдлэг мэдээллийг тэлэхийг зорилгоо болгон сүүлийн жилүүдэд иргэн бүрд ойлгомжтой байдлаар “Иргэдийн төсөв” товхимол болон төсвийн гүйцэтгэлийн мэдээг цахим хэлбэрээр бэлтгэн хүргэж ирсэн.

Монгол Улсын Засгийн газар, Сангийн яам төсөв, санхүү, нийгмийн харилцааны бүхий л хуулийн хүрээнд ямар зорилтыг шийдвэрлэж ямар үр дүнд хүрэх чиглэлээр боловсруулж Улсын Их Хуралд өргөн барьсан 2020 оны төсвийн төслийг иргэн танд хүргэх зорилгоор энэхүү товхимлыг бэлтгэн танилцуулж байна.

Энэхүү товхимолтой танилцсанаар Иргэн Та ирэх онд улс орны эдийн засгийн чадавх хэрхэн сайжрах, төсвийн орлогын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлснээр орлого хэрхэн тогтвортой өсөх, нийгмийн суурь үйлчилгээний чанар, хүртээмж, иргэдийн бодит орлого хэрхэн нэмэгдэх, улс орны хөгжил ямар түвшинд хүрэх чиглэлээр бодит мэдээллийг авна гэдэгт итгэлтэй байна.

Иргэн Та, Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн төслийн тухай мэдээллийг энэхүү товхимлоос гадна цахим хэлбэрээр Сангийн яамны www.mof.gov.mn, www.iltod.gov.mn хуудас болон олон нийтийн мэдээллийн сүлжээ Сангийн яамны фейсбүүк хуудаснаас авч болно.



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

ЧИМЭДИЙН ХҮРЭЛБААТАР



ТӨСВИЙН ТУХАЙ

- 8 Төсвийн бүрдэлт, хуваарилалт
- 9 Нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн хэсгүүд ба үе шатууд
- 10 Төсвийн үе шат, цаглабар

2020 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТӨСӨЛ

- 14 Төсвийн бодлого
- 16 Макро эдийн засгийн үзүүлэлтүүд
- 18 Нэгдсэн төсвийн үзүүлэлт

ТӨСВИЙН ОРЛОГО

- 22 Монгол Улсын 2020 оны төсвийн орлогын бүтэц
- 24 Гаалийн шинэчлэл
- 26 Татварын шинэчлэл
- 27 Газрын бүртгэл, төлбөрийн шинэчлэл

ТӨСВИЙН ЗАРЛАГА

- 30 Төсвийн зарлага эдийн засгийн ангиллаар
- 31 Урсгал зардлын тооцоололд баримталсан зарчмууд
- 32 Төсвийн зарлага ерөнхийлөн захирагчаар
- 33 Улсын төсвийн хөрөнгө оруулалт
- 34 Төрийн алба хаагч, иргэдийн нийгмийн баталгаа
- 36 Боловсрол
- 40 Эрүүл мэнд
- 43 Нийгмийн хамгаалал
- 46 Хүрээлэн буй орчин, байгаль хамгаалал
- 48 Эдийн засгийн үйл ажиллагаа
- 49 Аюулгүй байдал, нийгмийн хэв журам
- 50 Төрийн нийтлэг үйл ажиллагаа
- 51 Соёл урлаг, спорт, аялал жуулчлал

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР БОЛОН ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖ

- 54 Засгийн газрын өр
- 56 Засгийн газрын гадаад зээл, тусламж

ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

- 62 Улс, орон нутгийн төсвийн харилцаа
- 63 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан



01

ТӨСВИЙН ТУХАЙ

- Төсвийн бүрдэлт, хуваарилалт
- Нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн хэсгүүд ба үе шатууд
- Төсвийн үе шат, цаглабар

ТӨСВИЙН БҮРДЭЛТ, ХУВААРИЛАЛТ



Төсөв

Монгол Улсын төсөв нь төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор тодорхой хугацаанд буюу тухайн оны 1 сарын 1-ний өдрөөс 12 сарын 31-ний өдөр хүртэл хугацаанд хуримтлуулах, зарцуулах хөрөнгө, орлого, зарлага, өр төлбөр гэх зэргийг багтаасан хэрэгсэл юм.

Төсвийн орлого

Төсвийн нийт орлого нь татварын болон татварын бус орлого, тусламжаас бүрдэнэ. Нийт орлогоос тодорхой хэсгийг төсвийн тогтворжуулалтын сан, ирээдүйн өв санд хуваарилж үлдсэн орлого буюу нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогоор төсвийн зарлагыг санхүүжүүлдэг.

Төсвийн зарлага

Төсвийн зарлага нь урсгал болон хөрөнгийн зардлаас бүрдэх бөгөөд төрөөс иргэдэд үзүүлэх боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээ, аюулгүй байдлыг сахин хамгаалах, дэд бүтцийг хөгжүүлэх, бүтээн байгуулалт зэрэг чиг үүргийг гүйцэтгэхэд зарцуулагддаг.

Төсвийн тэнцэл

Төсвийн тэнцэл нь орлого, зарлагын зөрүү бөгөөд зарлагаас давсан орлогыг ашиг, орлогоос давсан зарлагыг алдагдал гэнэ. Төсвийн алдагдлыг Засгийн газрын бонд, гадаад зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлдэг бол ашгийг дараа оны төсвийн эх үүсвэрт зарцуулдаг.

НЭГДСЭН ТӨСВИЙН БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГҮҮД БА ҮЕ ШАТУУД



Монгол Улсын нэгдсэн төсөв нь Улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын төсөв болон орон нутгийн төсвөөс бүрддэг бөгөөд орон нутгийн төсвийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал баталдаг.

Улсын төсөв



Улсын төсөв нь нэгдсэн төсвийн 80 гаруй хувийг эзэлдэг ба Монгол Улсын ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, яамд болон түүний харьяа байгууллагуудын захиран зарцуулах төсвийг хэлнэ.

Нийгмийн даатгалын сангийн төсөв



Нийгмийн даатгалын сангийн төсвийн орлого нь нийгмийн даатгалын хуульд заасанчлан ажилтан болон ажил олгогчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэл болон улсын төсвөөс олгосон санхүүжилтээс бүрдэнэ. Уг орлогыг хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөрт зарцуулдаг.

Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв



Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв нь төр, иргэн, байгууллагаас төлсөн эрүүл мэндийн даатгалын шимтгэлээс бүрдэж төрөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлыг санхүүжүүлэхэд зарцуулагддаг.

Орон нутгийн төсөв



Орон нутгийн төсөв нь аймаг, нийслэл, сум дүүргийн ерөнхийлөн захирагч бүрдүүлэн, зарцуулах төсөв юм. Төсвийн алдагдалтай үед улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг олгодог бол ашигтай тохиолдолд улсын төсөвт орлого төвлөрүүлдэг. Уг шилжүүлгийн хэмжээг Улсын Их Хурал баталдаг.

ТӨСВИЙН ҮЕ ШАТ, ЦАГЛАБАР

Төсвийн боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, тайлагнах гэсэн үе шатууд нь тасралтгүй үргэлжилдэг ажиллагаа юм.

БОЛОВСРУУЛАХ

4 сарын 15 - 6 сарын 1

Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулж УИХ-аар батлуулна.

6 сарын 10 - 7 сарын 1

Төсвийн хязгаарын саналыг боловсруулж, Засгийн газраар батлуулна.

7 сарын 25 - 10 сарын 1

Төсвийн төслийн саналыг боловсруулж УИХ-д өргөн барина.

БАТЛАХ

УИХ **11 сарын 15** дотор төсвийн тухай хуулийг хэлэлцэн батална.

- Монгол Улсын төсвийн тухай хууль
- НДСангийн тухай хууль
- ЭМДСангийн тухай хууль

12 сарын 5-ны дотор аймаг, нийслэлийн төсвийг тухайн орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална

12 сарын 10-ны дотор сум, дүүргийн төсвийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

ТАЙЛАГНАХ

Төсвийн гүйцэтгэлийг сар, улирал, хагас жил, жилээр тайлагнана. Үндэсний аудитын газар тайланг хянаж дүгнэлт гарган УИХ-д өргөн мэдүүлнэ. УИХ тайланг хэлэлцэн хаврын чуулганаар Монгол Улсын төсвийн гүйцэтгэлийг батална.

- Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан
- УИХ-р батлагдсан жилийн төсвийн гүйцэтгэл

ГҮЙЦЭТГЭЛ

Жил бүрийн 1 сарын 1-ээс 12 сарын 31-ний өдрийг дуустал хуваарийн дагуу төсвийн орлогыг бүрдүүлж, зарцуулалтыг хийнэ. Төсвийн орлого Төрийн санд төвлөрөх ба батлагдсан хуваарийн дагуу төрийн сангаас санхүүжилтийг төсвийн байгууллагууд руу шилжүүлнэ.

Энэ хугацаанд:
- Сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ
- Улирал, хагас жилийн тайлан
- Жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлангууд гарна.









02

МОНГОЛ УЛСЫН 2020 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТӨСӨЛ

- Төсвийн бодлого
- Макро эдийн засгийн үзүүлэлтүүд
- Нэгдсэн төсвийн үзүүлэлт

ТӨСВИЙН БОДЛОГО

“ЦАХИМ, ИЛ ТОД, ҮР АШИГТАЙ”

Монгол Улсын Засгийн газраас 2020 оны төсвийг боловсруулахдаа дараах бодлогыг баримталсан:



Төсөв

Төсвийн сахилга батыг тууштай үргэлжлүүлэн, төсвийг эрүүлжүүлэх, алдагдлыг үе шаттай бууруулах бодлогыг хэрэгжүүлнэ.



Төсвийн тэнцэл

Бондын эргэн төлөлттэй холбоотойгоор төсвийн алдагдлыг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан хэмжээнээс сайжруулан цаашид ашигтай болгоно.



Төсвийн орлого

Гааль, татварын шинэчлэлийг хэрэгжүүлж, эдийн засгийн өсөлт, бизнесийн орчин, хөрөнгө оруулалт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. Газрын төлбөрийг бүрэн хураах чиглэлээр хууль, эрх зүйн орчныг сайжруулах, газрын бүртгэлийн цахимжуулах, ил тод болгох ажлыг хийж гүйцэтгэнэ.



Төсвийн зарлага

Зарлагын шинэчлэлийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, үр ашиг, хүртээмжийг нэмэгдүүлнэ.




ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийгмийн ач холбогдол бүхий эдийн засгийн үр ашигтай төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖ:

Гадаадын зээл, тусламжийг эдийн засаг, нийгэм, дэд бүтцийг сайжруулах чиглэлээр үр ашигтай зарцуулна.



ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР:

Өндөр хүүтэй үнэт цаасны төлбөрийг төсөв болон эдийн засагт дарамт үүсгэхгүйгээр төлж, өрийн зохистой менежментийг хэрэгжүүлнэ.



ОРОН НУТГИЙН ТӨСӨВ:


Төсвийн төвлөрлийг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлийг баримтална.

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД




ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН

40.7 их наяд төгрөг




ЭДИЙН ЗАСГИЙН БОДИТ ӨСӨЛТ

тогтвортой байна



ИНФЛЯЦЫН ТҮВШИН

Зорилтот түвшинг
хангахаар байна



* - Хүлээгдэж буй гүйцэтгэл

** - Төсөөлөл


Төсвийн төслийг макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтэд үндэслэн тооцдог. Нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүн 2019 оноос **12.0 хувиар**, нийт экспорт болон нийт импорт нэмэгдсэнээр гадаад худалдааны эргэлт **3.6 хувиар** өсөхөөр байна.



ГАДААД ХУДАЛДААНЫ НИЙТ ЭРГЭЛТ

14.5 тэрбум ам долларт хүрэхээр байна


Тэрбум ам. доллар



ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ

1.1 тэрбум ам долларын ашигтай

Тэрбум ам. доллар



Нийт экспорт



Нийт импорт



Тэнцэл

* - Хүлээгдэж буй гүйцэтгэл

** - Төсөөлөл

Дотоодын нийт бүтээгдэхүүн

Тухайн нутаг дэвсгэрт дотоод, гадаадын аж ахуй нэгж, байгууллага, иргэдийн нэг жилийн хугацаанд шинээр бий болгосон нийт бараа бүтээгдэхүүн

Эдийн засгийн бодит өсөлт

Инфляц буюу үнийн өсөлтийн нөлөөллийг тооцсон ДНБ-ий өсөлт

Инфляцын түвшин

Бүтээгдэхүүн үйлчилгээний үнийн ерөнхий түвшний өсөлтийн хувь

Гадаад худалдааны нийт эргэлт

Экспорт, импортын нийлбэр

Гадаад худалдааны тэнцэл

Экспорт импортын цэвэр зөрүү

Нийт экспорт

Монгол Улсын нутаг дэвсгэрээс хилийн чанадад гаргаж байгаа бараа, үйлчилгээ

Нийт импорт

Хилийн чанадаас Монгол Улсын нутаг дэвсгэрт оруулж байгаа бараа, үйлчилгээ

НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТ


/ТЭРБУМ ТӨГРӨГ/

ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН
НИЙТ ОРЛОГО

11,797.8

НИЙТ
ЗАРЛАГА

13,872.6



Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого **11,797.8 тэрбум** төгрөг, нийт зардал **13,872.6 тэрбум** төгрөг байхаар төлөвлөгдсөн. Нэгдсэн төсвийн нийт алдагдал **2,074.7 тэрбум** буюу **ДНБ-ий 5.1%-тай** тэнцэхээр байна.







03

ТӨСВИЙН ОРЛОГО


- Монгол Улсын 2020 оны төсвийн орлогын бүтэц
- Гаалийн шинэчлэл
- Татварын шинэчлэл
- Газрын бүртгэл, төлбөрийн шинэчлэл

Stx Pan


МОНГОЛ УЛСЫН 2020 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГЫН БҮТЭЦ

Ирэх онд гааль, татварын шинэчлэлийг хэрэгжүүлэн, газрын бүртгэлийг цахимжуулж, газрын төлбөр хураалтыг сайжруулан төсвийн орлогын эх үүсвэрийг бүрэн дайчилж нэгдсэн төсвийн нийт орлогыг 2019 оны батлагдсан дүнгээс **1.833 тэрбум төгрөг** буюу **16.6 хувиар** нэмэгдүүлэн **12.9** их наяд төгрөгт хүргэнэ.

Төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого **11,797.8** тэрбум төгрөг, ирээдүйн өв санд **977.0** тэрбум төгрөг, тогтворжуулалтын санд **125.2** тэрбум төгрөгийг тус тус төвлөрүүлнэ.



**ТӨСВИЙН
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН
НИЙТ ОРЛОГЫН БҮТЭЦ**



**ТӨСВИЙН ОРЛОГЫГ
НЭМЭГДҮҮЛЖ БҮЙ
ХҮЧИН ЗҮЙЛС**

2020 оны нэгдсэн төсвийн нийт орлого 2019 оны батлагдсан дүнгээс 1.8 их наяд төгрөгөөр өсөхөөр тооцсон.



Уул уурхайн голлох бүтээгдэхүүний төлөв	Нүүрс	Зэсийн баяжмал	Алт	Үнэ	Биет хэмжээ	Орлого тэрбум төгрөг
				75-125 \$/тн	42 сая тн	1,493.5 ↑14%
				5,991 \$/тн	1,225 мян тн	1,160.0 ↓-11%
				1,545 \$/унц	19 тн	166.0 ↑100%

ГААЛИЙН ШИНЭЧЛЭЛ

Экспорт, импортын бараа бүтээгдэхүүнд тавих хилийн хяналтыг сайжруулах, хэрэглэгч, үйлдвэрлэгчдийн эрх ашгийг хамгаалах, төсвийн орлогын суурийг өргөжүүлэх зорилгоор 2019 оноос эхэлсэн “Гаалийн шинэчлэл”-ийг 2020 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлж дуусгана.

РЕНТГЕН

Өндөр хүчин чадлын **РЕНТГЕН** болон **ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ** нэвтрүүлнэ

- Эрдэс бүтээгдэхүүний чанар, агуулга, тоо хэмжээг бүрэн тодорхойлно

- Газрын тосны бүтээгдэхүүний чанар, агуулга, тоо хэмжээг бүрэн тодорхойлно

- Хууль бус, чанаргүй бараа, бүтээгдэхүүнийг илрүүлж, таслан зогсооно



ЛАБОРАТОРИ

Экспортын бүтээгдэхүүн гарч байгаа хилийн боомтуудад олон улсын стандарт шаардлагад нийцсэн тоноглол, тоног төхөөрөмж бүхий **УУЛ УУРХАЙ ЭРДСИЙН ТӨРӨЛЖСӨН ЛАБОРАТОРИЙГ** байгуулж татвар, хураамжийг бүрэн ногдуулж, хураадаг болно

ТЕЛЕ ХЯНАЛТЫН СИСТЕМ

Гаалийн ерөнхий газрын дэргэд Шуурхай хяналт, удирдлагын төв байгуулан гаалийн нэгж, цэг бүрийг автомат **ТЕЛЕ ХЯНАЛТЫН СИСТЕМД** хамруулна

УХААЛАГ ГАРЦ

Радио давтамжит долгионоор тээврийн хэрэгслийг бүртгэх **“УХААЛАГ ГАРЦ” ХЯНАЛТЫН СИСТЕМИЙГ** нэвтрүүлнэ.

БООМТУУДЫН ХҮЧИН ЧАДЛЫГ НЭМЭГДҮҮЛНЭ

ГОЛЛОХ БООМТУУДЫГ олон улсын түвшинд нийцүүлэн цогцоор нь шинэчилнэ




Замын-Үүд боомт

Зам, талбайн хэмжээ **8** ДАХИН

Зорчигчдын тоо **4** ДАХИН

Ачаа тээврийн хэрэгслийн тоо **3** ДАХИН

Суудлын тээврийн хэрэгслийн тоо **7** ДАХИН



Гашуунсухайт боомт

Зам, талбайн хэмжээ **4** ДАХИН

Экспортын хүчин чадал **3** ДАХИН

Ачаа, зорчигч, тээврийн хэрэгслийн тоо **3** ДАХИН



Алтанбулаг боомт

Зам, талбайн хэмжээ **2** ДАХИН

Зорчигчдын тоо **3** ДАХИН

Ачаа, суудлын тээврийн хэрэгслийн тоо **4** ДАХИН



ТАТВАРЫН ШИНЭЧЛЭЛ

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 3 сарын 22-ны өдөр баталсан татварын багц хууль 2020 оны 1 сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлнэ.

ХҮРЭХ ҮР ДҮН:

Татварын таатай орчинг бүрдүүлснээр татварын ачаалал буурна.

1

Иргэдийн НӨАТ-ын урамшууллын буцаалтыг улирал бүр олгоно.

2

Татварын үйлчилгээг цахимжуулснаар ил тод, түргэн шуурхай үйлчилгээ авах боломжтой болж тайлангийн тоо цөөрнө.

3

Иргэдийн татварын боловсролыг дээшлүүлэх, татварын хууль тогтоомжийг сурталчлах ажлуудыг эрчимтэй зохион байгуулна.

4

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, БИЗНЕСИЙН ОРЧИНГ ДЭМЖИНЭ.

Татварын ачаалал буурч жилд гаргах тайлангийн тоог цөөрүүлнэ:

50 САЯ ТӨГРӨГ ХҮРТЭЛ

Борлуулалтын орлогын

1%

Хялбаршуулсан тайлан
1 удаа

300 САЯ ТӨГРӨГ ХҮРТЭЛ

Борлуулалтын орлого татвар ногдуулах орлогын

1%

Тайлан
2 удаа

1.5 ТЭРБУМ ТӨГРӨГ ХҮРТЭЛ

Борлуулалтын орлого татвар ногдуулах орлогын

10%

Тайлан
2 удаа

төлсөн татварын
90%
буцаана

6 ТЭРБУМ ТӨГРӨГ ХҮРТЭЛ

Татвар ногдуулах орлого татвар ногдуулах орлогын

10%

Тайлан
2 удаа

6 ТЭРБУМ ТӨГРӨГӨӨС ДЭЭШ

Татвар ногдуулах орлого татвар ногдуулах орлогын

25%

Тайлан
4 удаа

Одоогийн хуульд жилийн ашиг

3 тэрбум хүртэл 4 тайлан, 10% татвар, 3-с дээш бол 4 тайлан, 25% татвар

ИРГЭДИЙН ХУВЬД:

Орон сууц анх удаа худалдан авахад үзүүлэх татварын хөнгөлөлт 3 саяаас **6 сая** төгрөг болж нэмэгдэнэ.

Ипотекийн зээлийн хүүгийн дээд хэмжээ болон ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хүүгийн зөрүүгээр татварыг хөнгөлнө.

Алслагдсан аймагт үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуй нэгжийн татварыг **50-90%** хөнгөлнө.

Хөдөө аж ахуй, газар тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид тухайн бүтээгдэхүүнээс олсон орлогод ногдох татварыг **50 хувиар хөнгөлнө.**

КОМПАНИЙН ХУВЬД:

Орлогын албан татварын босго **6 тэрбум төгрөг** болж өснө.

Татварын тайланг **1 жилийн дотор залруулах** боломжтой.

Хүндэтгэн үзэх шалтгаантай бол татварын өрийг **2 жил хүртэл хугацаанд төлөх** боломжтой.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ БОЛОН БУСАД ЧИГЛЭЛЭЭР:

Монгол Улсад бүртгэлтэй компанийн гадаад, дотоодын зах зээлд нээлттэй арилжаалах бондод хөрөнгө оруулагчийн **хүүгийн орлогын татвар 5%**

Гадаад улсад төлсөн татварыг хасагдуулна

Барилга байгууламжийн элэгдэл тооцох хугацаа 40-өөс **25 жил болно.** (уул уурхайгаас бусад салбарт)

ГАЗРЫН БҮРТГЭЛ, ТӨЛБӨРИЙН ШИНЭЧЛЭЛ

ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД:

Газрын төлбөрийг гэрээний дагуу ногдуулж, хурааж байгаа нь
! газрын суурь үнэлгээ, иргэдийн
• Төлөөлөгчдийн Хурлаас
тогтоосон итгэлцүүр өөрчлөгдөх
тухай бүрт гэрээг шинэчлэн
байгуулах шаардлага үүсдэг.

Нэгж талбаруудын
мэдээлэл цахим хэлбэрт
• бүрэн шилжээгүй, ил тод
болоогүй.

Иргэд, аж ахуйн
нэгжүүд газрын
төлбөрөө төлөхөд
• олон шат дамжлага
дамжин цаг хугацаа
алддаг.

АВАХ АРГА ХЭМЖЭЭ:

✓ Нэгж талбаруудыг бүрэн
бүртгэж, мэдээллийг
баталгаажуулан газрын
кадастрын санд оруулах
ажлыг улсын хэмжээнд
хийж гүйцэтгэх.

✓ Нэгж талбарын
мэдээллийг
цахимжуулж, ил тод
болгох.

✓ Эзэмших, ашиглах
гэрээгээр бус хууль
тогтоомжид заасны
дагуу газрын төлбөрийг
ногдуулдаг болох.

✓ Газрын төлбөр төлөх
харилцааг бүрэн
цахимжуулж иргэд,
аж ахуйн нэгжийн цаг
хугацаа, зардал мөнгийг
хэмнэх.

✓ Сум, дүүргийн төсөвт
газрын төлбөрийн
орлогын **40** хувийг
хуваарилах замаар
тухайн орон нутагт
газрын асуудлаар
үүсээд байгаа
хүндрэлээ шийдвэрлэх
санхүүгийн эх
үүсвэрийг бүрдүүлэх.

ХҮРЭХ ҮР ДҮН:

✓ Газрыг бүрэн бүртгэж,
төлбөр ногдуулах, төлөх үйл
ажиллагааг хялбарчилна.

✓ Сум, дүүргийн татварын
газарт газрын асуудлаа
бие даан шийдвэрлэх
боломжийг бүрдүүлнэ.





04

ТӨСВИЙН ЗАРЛАГА

- Төсвийн зарлага эдийн засгийн ангиллаар
- Урсгал зардлын тооцоололд баримталсан зарчмууд
- Төсвийн зарлага ерөнхийлөн захирагчаар
- Улсын төсвийн хөрөнгө оруулалт
- Төрийн алба хаагч, иргэдийн нийгмийн баталгаа
- Боловсрол
- Эрүүл мэнд
- Нийгмийн хамгаалал
- Хүрээлэн буй орчин, байгаль хамгаалал
- Эдийн засгийн үйл ажиллагаа
- Аюулгүй байдал, нийгмийн хэв журам
- Төрийн нийтлэг үйл ажиллагаа
- Соёл урлаг, спорт, аялал жуулчлал

ТӨСВИЙН ЗАРЛАГА ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛЛААР

Нийт зарлагын 2019 оны батлагдсан дүнгээс **2,283.5 тэрбум** төгрөгөөр өснө. Урсгал зардал **1,833.0** тэрбум төгрөгөөр өсөж байгаа ба уг өсөлтийн **61%** нь цалин, тэтгэвэр, тэтгэмж, шилжүүлгийн зардлыг нэмэгдүүлэх бодлоготой холбоотой. Хөрөнгийн зардал **3,678.9 тэрбум** төгрөг болж **13.4** хувиар өссөн нь нийгэмд нэн шаардлагатай хөрөнгө оруулалт болох сургууль, цэцэрлэг шинээр барьж ашиглалтад оруулах зардал, мөн Байгалийн түүхийн музейн барилга, Үндэсний урлагийн их театр, Шинжлэх ухаан инновацийн төвийн кластер зэрэг салбаруудын бүтээн байгуулалтын ажлуудыг хийхээр төлөвлөсөнтэй холбоотой байна.



УРСГАЛ ЗАРДЛЫН ТООЦООЛОЛД БАРИМТАЛСАН ЗАРЧМУУД



Цалин, тэтгэвэр,
тэтгэмжийг инфляцын
түвшинтэй уялдуулж
нэмэгдүүлнэ



Төрийн үйлчилгээний
чанар, хүртээмжийг
нэмэгдүүлэхтэй холбоотой
нийгмийн хамгаалал, боловсрол,
эрүүл мэнд, аюулгүй байдлыг
хангах зардлыг төсөвт тусгана.



Шинээр батлагдсан хууль
тогтоомж болон шинэ
хөрөнгө оруулалттай холбоотой
нэмэгдэх шаардлагатай орон
тоо, урсгал зардлыг тусгана.



Орон нутагт үйл ажиллагаа
явуулж байгаа төсвийн
байгууллагын тээвэр шатахуун,
түлш халаалтын зардлыг
индексжүүлэн нэмэгдүүлнэ.



УИХ, орон нутгийн ээлжит
сонгууль, хүн ам, орон
сууцны тооллого, 2020 оны
Токиогийн олимпод оролцох
зэрэг нэг удаагийн шинжтэй арга
хэмжээний зардлыг тусгана.

Урсгал зардлын өөрчлөлтийг ангилж үзвэл нийт өөрчлөлтийн **61.0 хувь** нь цалин, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэхэд, **5.4 хувь** нь байр ашиглалт, хангамжийн бараа материалын зардалд, **4.3 хувь** нь хоол хүнс, норматив зардалд, **5.2 хувь** нь зээлийн хүүгийн зардалд, **1.7 хувь** нь татаас дэмжлэгт, **0.8 хувь** нь гадаад зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд, **15.6 хувь** нь нэг удаагийн шинжтэй болон бусад арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой байна.

ТӨСВИЙН ЗАРЛАГА ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧААР

УРСГАЛ
ЗАРДАЛ
7,344.8

ХӨРӨНГИЙН
ЗАРДАЛ
2,089.4

ГАДААД ЗЭЭЛ
ТУСЛАМЖ
1,446.6

ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ
ЦЭВЭР ЗЭЭЛ
-28.4

НИЙТ
ТӨСӨВ
10,852.3

/Тэрбум төгрөг/

Сангийн сайд	1,531.9	175.1	1,446.6	-65.0	3,088.6	
БСШУС-ын сайд	1,510.7	622.3		49.8	2,182.9	
ХНХ-ын сайд	1,519.3			22.3	1,541.6	
Эрүүл мэндийн сайд	825.4			117.8	943.2	
ХЗДХ-ын сайд	574.9			47.9	602.1	
Монгол Улсын Ерөнхий сайд	111.0			355.0	465.9	
Зам, тээврийн хөгжлийн сайд	12.4			330.8	343.2	
Батлан хамгаалахын сайд	283.2			12.0	295.2	
Барилга, хот байгуулалтын сайд	25.7		157.4	5	228.1	
ХХААХҮ-ын сайд	163.4			20.8	2.4	186.6
Монгол Улсын Шадар сайд	156.9			20.9	177.8	
Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	144.8			30.4	175.2	
Гадаад харилцааны сайд	90.8			2.0	92.8	
Эрчим хүчний сайд	27.5			60.8	88.3	
Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга	37.5			26.1	63.6	
Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	56.3				56.3	
Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комиссын дарга	54.5				54.5	
Улсын ерөнхий прокурор	36.0			9.2	45.2	
Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	14.1			28.8	42.8	
УИХ-ын дарга	40.3			2.6	42.9	
Сонгуулийн ерөнхий хорооны дарга	38.1				38.1	
Авлигатай тэмцэх газрын дарга	26.0			1.1	27.1	
Монгол Улсын Ерөнхий аудитор	22.1			1.0	23.1	
Үндэсний статистикийн хорооны дарга	15.4			0.7	16.0	
Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч	4.7			4.5	9.2	
Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга	4.9				4.9	
Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга	4.8				4.8	
Санхүүгийн зохицуулах хорооны дарга	4.8				4.8	
Төрийн албаны зөвлөлийн дарга	3.6				3.6	
Үндсэн хуулийн цэцийн дарга	2.3				2.3	
Хүний эрхийн үндэсний комиссын дарга	1.3				1.3	


Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрт холбогдох салбар, чиглэлийн хувьд төсвийг удирдах дээд удирдлага юм.

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Ирэх онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, орон нутаг болон салбаруудад тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашиг бүхий төслүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. Нийт **1,982.2** тэрбум төгрөгийн хөрөнгө

оруулалтаар **1205** төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын **86** хувь нь бүтээн байгуулалтын төслүүд бол үлдсэн **14** хувь нь их засвар хийх, тоног төхөөрөмж худалдан авах, ТЭЗҮ, зураг төсөв боловсруулахад шаардлагатай санхүүжилт байна.



ОНЦЛОХ ТӨСЛҮҮД



Боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж дуусгана.

	2017	2018	2019	2020
Нийт 248 цэцэрлэг	34	22	134	58
Нийт 173 сургууль	22	10	58	83


Эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмжийг иргэдэд хурдан шуурхай хүргэх, эмнэлгийн орчин нөхцөлийг сайжруулна.

	2017	2018	2019	2020
Нийт 102 эмнэлэг	9	11	35	47

Дээрх хүснэгтэд ашиглалтад орох сургууль, цэцэрлэг, эмнэлгийн тоог харуулсан болно.

ТӨРИЙН АЛБАН ХААГЧ, ИРГЭДИЙН НИЙГМИЙН БАТАЛГАА

ЦАЛИН, ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙГ ИНФЛЯЦЫН ТҮВШИНТЭЙ УЯЛДУУЛЖ НЭМНЭ.



ТӨРИЙН АЛБАНААС ТЭТГЭВЭРТ ГАРАГЧИЙН ТОО

Төрийн албан хаагч тэтгэвэрт гарахад 36 сар хүртэлх цалинтай тэнцэх хэмжээтэй тэтгэмжийг төрөөс олгодог. Ирэх онд 5.7 мянган албан хаагч тэтгэвэрт гарах ба уг тэтгэмжид **127.7 тэрбум** төгрөгийг төсөвлөсөн.

ТӨРИЙН АЛБАН ХААГЧ	1,404 ХҮН	БОЛОВСРОЛЫН САЛБАРЫН АЖИЛЧИД	1,654 ХҮН	ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН АЖИЛЧИД	928 ХҮН
Төрийн жинхэнэ албанаас тэтгэвэрт гарах хүний тоо: 1 сарын цалин*ажилласан жил 36 сарын цалингаас ихгүй		Төрийн өмчийн сургууль, цэцэрлэгт 25 ба түүнээс дээш жил ажилласан хүний тоо 1 сарын цалин*ажилласан жил 36 сарын цалингаас ихгүй		Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад 25 жил, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд 10 ба түүнээс дээш жил ажилласан хүний тоо 1 сарын цалин*ажилласан жил 36 сарын цалингаас ихгүй	
ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН ХААГЧИД	1,308 ХҮН	БУСАД	438 ХҮН		
Төрийн тусгай албанд эрэгтэй 25-с доошгүй, эмэгтэй 20-оос доошгүй жил ажилласан хүний тоо 36 сарын цалинтай тэнцэх		Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тухай хууль зэргээр тэтгэвэрт гарах албан хаагчид багтана.			

ТЭТГЭМЖ

Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж буй зарим албан хаагчдад тэтгэмж олгодог ба уг зардалд 39.6 тэрбум төгрөг тусгасан.

Харьяа яам	Хүний тоо	Нийт зардал
БХЯ	127	1.0
ЭМЯ	2,247	9.7
ХЗДХЯ	810	11.1
БСШУСЯ	3,752	15.6
ХНХЯ	341	2.3
НИЙТ	7,277	39.6



21 ЖИЛ АЖИЛЛАСАН БАГШ БАТЫН ЦАЛИНГИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ЖИШЭЭ

Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 57.2.4-т заасны дагуу төрийн үйлчилгээ (ТҮ)-ний албан хаагчдад төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 2020 оноос шинээр олгож эхлэхтэй холбоотойгоор **142.7** тэрбум төгрөг төсөвлөсөн.

	2018 он	2019 он	2020 он
ҮНДСЭН ЦАЛИН	683,879	787,701	850,717
МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ	102,582	118,155	127,608
УР ЧАДВАР	102,582	118,155	127,608
АНГИ УДИРДАХ	68,388	78,770	85,072
ЗААХ АРГА	34,194	39,385	42,536
КАБИНЕТ	34,194	39,385	42,536
ОРОН НУТГИЙН НЭМЭГДЭЛ	68,388	78,770	85,072
ТӨРИЙН АЛБА ХААСАН ХУГАЦААНЫ НЭМЭГДЭЛ	0	0	170,143
НИЙТ ЦАЛИН * ХӨЛС	1,094,207	1,260,321	1,531,292

* НДШ болон ХХОАТ суутгаагүй дүн

Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг тухайн төрийн албан хаагчийн төрийн байгууллагад ажилласан хугацааг харгалзан түүний албан тушаалын сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож олгоно:

Төрийн алба хаасан хугацаа	6-10 жил	11-15 жил	16-20 жил	21-25 жил	26 ба түүнээс дээш
Албан тушаалын сарын үндсэн цалингаас бодох хувь	5%	10%	15%	20%	25%



36 ЖИЛ АЖИЛЛАСАН ҮЙЛЧЛЭГЧ ЧИМГЭЭГИЙН ТЭТГЭВЭРТ ГАРАХ ТЭТГЭМЖИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ЖИШЭЭ

Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжид **141.1** тэрбум төгрөг төсөвлөгдсөн.

2019 он	ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭ	2020 он /Мянган төгрөг/
5,168.4		15,505.2

12 сарын цалинтай дүйцэхүйц 1 удаагийн тэтгэмж

36 сарын цалинтай дүйцэхүйц 1 удаагийн тэтгэмж

БОЛОВСРОЛ

ТӨСВИЙН ОНЦЛОГ

- 2012 оноос хойш нэмэгдүүлээгүй байсан цэцэрлэгийн хоол, ерөнхий боловсролын сургуулийн үдийн цай болон дотуур байрны хоолны зардлын тарифыг **50 хувь** нэмэгдүүлнэ.
- Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд суралцагсдын тэтгэлгийг **2 дахин нэмж**, сар бүр **200,000** төгрөг олгоно.
- Боловсролын салбарын төрийн үйлчилгээний ажиллагсад төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг авдаг болно.

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ



ХҮҮХЭД ХАРАХ ҮЙЛЧИЛГЭЭ

Хүүхэд харах үйлчилгээг үргэлжлүүлнэ. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд болон хилийн заставт ажиллагсдын хүүхдийг хүүхэд харах үйлчилгээнд нэмж хамруулна



ЦЭЦЭРЛЭГИЙН ХҮҮХДИЙН ХООЛ

Ердийн цэцэрлэгийн 1 хүүхдийн 1 өдрийн хоолны зардал **1,650 төгрөг**, 24 цагийн, сувилалын болон тусгай цэцэрлэгийн хоолны зардал **2,400 төгрөг** байгааг **50 хувиар** нэмэгдүүлж, үүнд шаардлагатай **29.6 тэрбум** төгрөгийг нэмж төсөвлөн, нийт **272.0 мянган** цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг **96.5 тэрбум** төгрөгт хүргэнэ.



1 ХҮҮХДЭД 1 ЖИЛД ОЛГОХ ХУВЬСАХ ЗАРДАЛ

Сумын цэцэрлэгт: **998,200 төгрөг**
Аймгийн төвд: **812,300 төгрөг**
Нийслэлд: **807,800 төгрөг**

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ



54.1
57.8% ↑
/Тэрбум төгрөг/

ҮДИЙН ЦАЙ ХӨТӨЛБӨР

“Үдийн цай” хөтөлбөрт ЕБС-н 1-5-р ангийн сурагчид хамрагддаг бөгөөд ердийн сургуулийн 1 сурагчийн 1 өдрийн тарифийг **900 төгрөг**, тусгай сургуулийн суралцагчийн үдийн хоолны тариф **2,400 төгрөг** болгож 50 хувиар нэмэгдүүллээ. Ирэх онд **352 мянган** сурагчийг үдийн цай хөтөлбөрт хамруулахаар тооцож зардлыг **19.0 тэрбум төгрөгөөр** нэмэгдүүлж, нийт **54.3 тэрбум төгрөгт** хүргэнэ.



30.0
33.8% ↑
/Тэрбум төгрөг/

ДОТУУР БАЙРНЫ ХООЛ

Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдрах нэг хүүхдийн хоногийн хоолны зардал **2,315 төгрөг** байсныг **50%** нэмэгдүүлж **3,472 төгрөгт** хүргэнэ. Үүнтэй холбоотойгоор **7.6 тэрбум төгрөгийг** нэмэгдүүлж, нийт төсвийг **30.1 тэрбум төгрөгт** хүргэхээр тооцлоо. Уг хөтөлбөрт **35 мянган** сурагч хамрагдана.



7.0
100% ↑
/Тэрбум төгрөг/

СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГИЙН ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛНЭ

Гурван ээлжгүй сургууль, хүүхэд бүр цэцэрлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор **2020** онд ашиглалтад орох **61** хүүхдийн цэцэрлэг, **32** ерөнхий боловсролын сургуульд шаардлагатай орон тоо болон зардлыг төсөвт тусгалаа. Мөн нийслэлийн хэмжээнд цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, гурван ээлжээр хичээллэж байгаа сургуулиудын асуудлыг шийдвэрлэхэд зориулж **12** сургууль, **8** цэцэрлэгийн байрыг түрээслэх зардал болох **2.0 тэрбум төгрөгийг** төсвийн төсөлд тусгалаа



улсын сургууль

ХҮҮХДИЙН ТОО

611,161

БАГШ, АЖИЛЧДЫН ТОО

47,199











Төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн нэг суралцагчид байршил болон сургуулийн ангиллаас хамааран **286,900-683,100** төгрөгийн хувьсах зардлыг олгоно.

ДЭЭД БОЛОВСРОЛ

Боловсролын зээлийн сангаас санхүүжих оюутанд чиглэсэн хөтөлбөрүүд хөтөлбөрүүд

/Тэрбум төгрөг/

 Оюутны нийтийн тээврийн хөнгөлөлт	5.6
 Нэн ядуу, малчин, зарим суралцагчдад олгох тэтгэлэг	12.6
 Гадаадад суралцагсдын зардал	3.5
 Багш мэргэжлээр суралцагсдад олгох сургалтын төлбөр	2.8
 Оюутны сургалтын төлбөрийн зээл	33
 Дэлхийн шилдэг 100 сургуульд суралцагчдын сургалтын төлбөрийн зээл	14.5
 Засгийн газрын гэрээгээр гадаадад суралцагчдад олгох зээл	7.3
 Бусад тэтгэлэгүүд	2.4

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ

Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын байгууллагын элсэгчдийг дэмжих, энэ чиглэлийн боловсон хүчнийг нэмэгдүүлэх зорилгоор олгодог тэтгэлэгийг **2 дахин** нэмэгдүүлж **40.0 мянган** суралцагчийг хамруулахаар төлөвлөв.

МСҮТ-Д
СУРАЛЦАГСДЫН
ТЭТГЭЛЭГ

80.0
95.1%
/Тэрбум төгрөг/



ЭРҮҮЛ МЭНД

“Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоог бүрдүүлэн, оношилгоо үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хүн амын дундаж наслалтыг уртасгах талаар тодорхойлсон зорилтыг хангах хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.



2019 оноос эхлэн хэрэгжсэн “ЭРҮҮЛ ШҮД-ЭРҮҮЛ ХҮҮХЭД” хөтөлбөр үргэлжлэн хэрэгжинэ.

77.5 2019 оны 8 сарын байдлаар хамрагдсан хүүхдийн тоо
Мянга

153 Гэрээт хувийн эмнэлгийн тоо

5.3 ↑ Зардлын өсөлт
/Тэрбум төгрөг/



Эрүүл мэндийн байгууллагын бие даасан байдлыг бэхжүүлэх замаар эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй тогтолцоог бий болгоно.



Төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээний тарифын ялгааг арилгана.

26.7 ↑ Зардлын өсөлт
/Тэрбум төгрөг/



Төр хариуцах тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

6.2 ↑ Зардлын өсөлт
/Тэрбум төгрөг/




НИЙТ ЗАРДЛЫН ӨӨРЧЛӨЛТ

Цалин, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх



Шинээр ашиглалтад орох эмнэлгүүдийн зардал



Төр хариуцах эмнэлгийн тусламж үйлчилгээний хүлээгдлийг арилгах, хүртээмжийг нэмэгдүүлэх



Бусад зайлшгүй шаардлагатай эмнэлгийн хоол, нормын хувцас, тоног төхөөрөмжийн засвар зэрэгт



ОНЦЛОХ АРГА ХЭМЖЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ



Дархлаажуулалтын вакцин болон шаардлагатай эмнэлгийн хэрэгслийг худалдан авах зардалыг 3 тэрбумаар өсгөж 12 тэрбум төгрөгт хүргэлээ


ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САН



Нийт эрүүл мэндийн даатгалын сангаас иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нэмэгдүүлэх, чанаржуулах чиглэлээр **506.5 тэрбум төгрөгийг** төлөвлөсөн. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагын өсөлт **98.8 тэрбум төгрөг**.

82.6↑

Эмнэлгүүдийн өрсөлдөөнийг бий болгож, чанарыг сайжруулах зорилгоор төрийн болон хувийн хэвшлийн хоёр, гурав дахь шатлалын эмнэлгүүдэд олгож буй санхүүжилтийн тарифын ялгааг арилгах



/Тэрбум төгрөг/

13.8↑

Урьдчилан сэргийлэх, үзлэг шинжилгээнд хамрагдах даатгуулагчийн тоог нэмэгдүүлэх

2.1↑

Эмийн үнийн хөнгөлөлтийн хүртээмжийг нэмэгдүүлэх

1.1↑

Нийгмийн даатгалын байгууллагад олгох үйл ажиллагааны зардал

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

ЭХЧҮҮДИЙН НИЙГМИЙН ХАМГААЛЛЫГ САЙЖРУУЛНА.

ЭХЧҮҮДЭД ЧИГЛЭСЭН ХУУЛИЙН ӨӨРЧЛӨЛТ

- Төрүүлсэн болон гурав хүртэл настайд нь үрчлэн авч зургаан нас хүртэл хүүхдээ өсгөсөн эхийн НДШ төлсөн нийт хугацаан дээр төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхэд бүрийн тоогоор нэг жил зургаан сарыг нэмж тооцох.
- Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан эхийн жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг цалин хөлснийх нь 70 хувиар тооцож байсныг 100 хувиар тооцож олгох.
- Нийгмийн даатгалд даатгуулаагүй эх хүүхдээ асрах хугацаанд төлбөл зохих шимтгэлийн 50 хувийг өөрөө, үлдэх 50 хувийг төрөөс.
- Сайн дураар даатгуулсан эхийн хүүхдээ асрах хугацаанд төлбөл зохих шимтгэлийг өөрөө хариуцаж байсныг холбогдох хуульд өөрчлөлт оруулж 50 хувийг өөрөө, үлдэх 50 хувийг тэтгэмжийн даатгалын сангаас.



ЭХИЙН АЖИЛЛАСАН ЖИЛИЙГ ХҮҮХДИЙН ТООГООР НЭМЭГДҮҮЛЭХ ХУУЛИЙН ЖИШЭЭ:

Шимтгэл төлсөн жил

Нэмэгдэх жил 4хүүхэд *1,5жил

Шинэ хуулиар

27 жил + 6 ЖИЛ = 33 жил

Тэтгэврийн өөрчлөлт
444.0 - 492.0 ↑



Хөнгөлөлттэй нөхцөлөөр эрт тэтгэвэрт гарсан зарим эхчүүд, эмэгтэйчүүдийн тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ
12.7 ↑
ТЭРБУМ ТӨГРӨГ

1 ХҮНД САРД НЭМЭГДЭХ ДҮН
50.0
МЯНГАН ТӨГРӨГ

ХАМРАГДАХ ХҮНИЙ ТОО
21.2
МЯНГА



Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид 1995-2019 оны хооронд төлж чадаагүй шимтгэлээ нэг удаа нөхөн төлж, 2020 оноос тэтгэвэр авах боломжтой болно

ЖИШЭЭ:

ШИМТГЭЛ НӨХӨХ ЖИЛ

10жил

НӨХӨЖ ТӨЛБӨЛ ЗОХИХ ДҮН

5,040.0
МЯНГАН ТӨГРӨГ

ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭ ЖИЛД

3,240.0
САРД 270.0
МЯНГАН ТӨГРӨГ

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САН

ХАЛАМЖИЙН САНГИЙН НИЙТ ЗАРЛАГА **756.6 ТЭРБУМ ТӨГРӨГ.**

	2020 он	Өөрчлөлт
Хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	240.0	10% ↑
Халамжийн тэтгэвэр	117.6	18% ↑
Цалинтай ээж	110.7	14% ↑
Асаргааны тэтгэмж	50.2	34% ↑
Хүнс тэжээлийн тусламж, дэмжлэг	42.2	-
Халамжийн бусад хөнгөлөлт	31.1	-
Алдарт эхийн тэтгэмж	29.4	-
Амьжиргааг дэмжих тусламж	27.8	-
Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт	26.1	-
Насны хишиг	22.3	-
Жирэмсэн эхийн тэтгэмж	18.1	-
Тэтгэвэр, тэтгэмж нэмэгдүүлэх эх үүсвэр	17.5	17% ↓
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэмж	12.3	-
Ахмад дайчин, алдар цолтон	6.4	-
Үйл ажиллагааны зардал	2.8	-
Олон нийтийн оролцоо түшиглэсэн	1.8	-
Асрамжийн үйлчилгээ	0.3	50% ↑

(тэрбум төгрөг)

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН

Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага (тэрбум төгрөг)

ОРЛОГО

2,291.8

2019 оноос
43.0%



ЗАРЛАГА

2,510.7

2019 оноос
21.4%



Нийт орлого **2,291.8** тэрбум төгрөг

Тэтгэврийн даатгал
1,876.1

Тэтгэмжийн даатгал
167.1

ҮОМШӨ-ний даатгал
206.7

Ажилгүйдлийн даатгал
41.9

+

Татаас, шилжүүлэг **400.5** тэрбум төгрөг

Улсын төсвөөс олгох татаас
399.4

ЭМДСангийн шилжүүлэг
1.1

Нийт зарлага **2,510.7** тэрбум төгрөг

ТЭТГЭВРИЙН ДААТГАЛ
2,251.9

Өндөр настны тэтгэвэр
1,681.1

Тахир дутуугийн тэтгэвэр
334.7

Цэргийн тэтгэвэр
155.9

Тэжээгчээ алдсаны тэтгэвэр
80.1

ТЭТГЭМЖИЙН ДААТГАЛ
143.7

Жирэмсэн болон амаржсан эхийн тэтгэмж
99.3

Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж
28.8

Оршуулгын тэтгэмж
15.6

ҮОМШӨ-НИЙ ДААТГАЛ
35.0

ҮОМШӨ-ний тэтгэвэр, тэтгэмж
31.1

ҮОМШӨ-тэй даатгуулагчийн сувиллын зардал
2.0

Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал
1.9

АЖИЛГҮЙДЛИЙН ДААТГАЛ
50.9

Ажилгүйдлийн тэтгэмж
50.9

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ
29.2

Нийгмийн даатгалын үйл ажиллагааг явуулахад шаардагдах бусад зардлууд
29.2

БҮЛЭГ 4 | ТӨСВИЙН ЗАРЛАГА

ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ

АГААРЫН БОХИРДЛЫГ
БУУРУУЛАХ
АРГА ХЭМЖЭЭГ
САНХҮҮЖҮҮЛЭХ

41.4 ↑
тэрбум төгрөг

Агаарын бохирдлыг бууруулахад зориулан нэмэгдүүлж байгаа хөрөнгийг нийслэлд сайжруулсан түлшний түгээлт, борлуулалтыг зохион байгуулах болон агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлэх бусад арга хэмжээнд зарцуулна.

**БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ХАНГАХ
БОДЛОГЫН ЗОРИЛТУУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ ЭХЭЛНЭ.**

3.9 ↑

тэрбум төгрөг

**ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТГИЙН ХЭМЖЭЭГ
НЭМЭГДҮҮЛЭХ, ХАМГААЛАХ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ**



Тусгай хамгаалалтад авах **1.9 сая** га газар нутагт суурь судалгаа хийх.



Улсын тусгай хамгаалалттай **27.9 сая** га газарт хамгаалалтын менежментийг сайжруулах.

**ХАМГААЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН
ХҮРЭЭНД АВАХ АРГА ХЭМЖЭЭ:**



Түймэр, хууль бус мод бэлтгэл, хулгайн ан болон байгалийн нөөцийн зохисгүй ашиглалтаас сэргийлэх арга хэмжээ авах



Биотехникийн арга хэмжээ авах



Хамгаалагдаж байгаа биологийн олон янз байдалд мониторинг судалгаа хийх



Орчны бүсийн айл өрхөд тусгай хамгаалалттай газар нутгийн ач холбогдол, экосистемийн үйлчилгээний талаар сургалт зохион байгуулах

**ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ
2030-ЫН 2020 ОНД ХҮРЭХ
ЗОРИЛТОТ ТҮВШИН:**

Тусгай хамгаалалттай газар нутгийн нийт нутаг дэвсгэрт эзлэх хэмжээг **21 хувьд** хүргэнэ.

Тусгай хамгаалалтад авсан гол мөрний урсац бүрэлдэх эхийн нийт нутаг дэвсгэрт эзлэх хэмжээг **50 хувьд** хүргэнэ.

1.3 ↑

тэрбум төгрөг

**МОНГОЛ УЛСЫН НИЙТ НУТАГ ДЭВСГЭРИЙН ЦӨЛЖИЛТ, ГАЗРЫН
ДОРЙТОЛД ӨРТСӨН ГАЗАР НУТГИЙН ХЭМЖЭЭГ БУУРУУЛАХ**



Элсний нүүлтийг зогсоох механик хаалт хийх, байгалийн унаган ашигт ургамал тарих



Эвдэрч доройтсон газрыг нөхөн сэргээх арга хэмжээг салбар хоорондын уялдааг ханган хэрэгжүүлэх



Ойн доройтол бүхий ойт хээрийн бүс, ойгүй тал хээрийн бүсийг байгалийн болон таримал ойгоор ойжуулах, баянбүрдийг нутгийн ургамал, модоор нөхөн сэргээх




Монгол Улсын хэмжээнд хөрсний үржил шимийн динамикийн мэдээллийн сан бүрдүүлж, газрын доройтол, цөлжилтийн зураглал гаргах



Иргэд, олон нийт, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад цөлжилтийн хор уршгийг таниулах, тэмцэх арга технологид суралцуулах

ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА



15.0

тэрбум төгрөг

ДАРХАНЫ АЖ ҮЙЛДВЭРИЙН ПАРК-ийн бүтээн байгуулалтын зээлийн хүүгийн татаас.

ХАА-Н САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ

урамшуулалд нийт 66.6 тэрбум төгрөг төсөвлөв.

Махны зээлийн хүүгийн хөнгөлөлт

20 мянган тонн мах бэлтгэх



9.2

тэрбум төгрөг

2019 он

4.7

2020 он

4.5 ↑

тэрбум төгрөг

Улаан буудайн урамшуулал



23.0

тэрбум төгрөг

2019 он

13.0

2020 он

10.0 ↑

тэрбум төгрөг



11.8

тэрбум төгрөг

Арьс ширний урамшуулал



22.6

тэрбум төгрөг


Ноосны урамшуулал



4.9 ↑

тэрбум төгрөг

Баруун бүсийн эрчим хүчний системийн хэвийн үйл ажиллагааг хангахад зориулж олгох татаас 4.9 тэрбум нэмэгдүүлнэ



5.0 ↑

тэрбум төгрөг

Харгиа цэвэрлэх байгууламжийг барихад 5.0 тэрбум төгрөг төсөвлөсөн



55.0 ↑

тэрбум төгрөг

Авто замын сангийн орлогын эхүүсвэрийг замын засвар, арчлалтад бүрэн зарцуулна.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, НИЙГМИЙН ХЭВ ЖУРАМ

Төсвийн онцлог, өсөлтийн шалтгаанууд.

2.2↑

тэрбум төгрөг

Гал унтраах,
эрэн хайх,
аврах анги,
салбар,
бүлгүүдийн
хүчин чадлыг
нэмэгдүүлнэ

4.4↑

тэрбум төгрөг

Тусгай
эмнэлгүүдэд
ЭМД-ын
сангаас олгох
санхүүжилтийг
өсгөнө

0.5↑

тэрбум төгрөг

Зэвсэгт хүчний
анги, салбарын
эмнэлгийн
тусламж
үйлчилгээг
сайжруулна.

1.3↑

тэрбум төгрөг

Хар тамхитай
тэмцэх үйл
ажиллагааг
эрчимжүүлнэ

4.8↑

тэрбум төгрөг

228 экологийн
цагдаа байгаль
орчны эсрэг
гэмт хэрэгтэй
тэмцэнэ

9.9↑

тэрбум төгрөг

Мөнгө
угаах болон
терроризмыг
санхүүжүүлэхтэй
тэмцэх тогтолцоог
сайжруулна

ТӨРИЙН НИЙТЛЭГ ҮЙЛ АЖИЛЛАГАА

УИХ, ИТХ-ЫН ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН ТӨСӨВ



Сонгуулийн ерөнхий хороо

37.1

ТЭРБУМ ТӨГРӨГ



Цагдаагийн ерөнхий газар

1.0

ТЭРБУМ ТӨГРӨГ



Улсын бүртгэлийн ерөнхий газар

4.8

ТЭРБУМ ТӨГРӨГ



Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар

0.1

ТЭРБУМ ТӨГРӨГ

УИХ | Орон нутаг
20.5 | **16.6**

НИЙТ ЗАРДАЛ

43.0 ТЭРБУМ ТӨГРӨГ

ХЭЛМЭГДЭГСДЭД ОЛГОХ НӨХӨН ОЛГОВОР

2019 ОНООС
48.8 ↑
ТЭРБУМ ТӨГРӨГ

13.2.1. Улс төрийн хилс хэрэгт холбогдуулан цаазаар авах ялаар шийтгүүлсэн хэлмэгдэгчийн эхнэр /нөхөр/, эсхүл хэлмэгдэгчийн төрсөн болон үрчилж авсан хүүхэд, хэлмэгдэгчийг нас барснаас хойш 10 сараас илүүгүй хугацааны дотор төрсөн хүүхдэд 80 сая төгрөг;

13.2.2. Улс төрийн хилс хэрэгт холбогдуулан хорих ялаар шийтгүүлсэн хэлмэгдэгч, хэлмэгдэгч нас барсан бол түүний эхнэр /нөхөр/, эсхүл хэлмэгдэгчийн төрсөн болон үрчилж авсан хүүхэд, хэлмэгдэгчийг нас барснаас хойш 10 сараас илүүгүй хугацааны дотор төрсөн хүүхдэд 40 сая төгрөг.

2019 ОН

5.0

ТЭРБУМ ТӨГРӨГ

2020 ОН

53.9

ТЭРБУМ ТӨГРӨГ

2019 ОНООС
48.8 ↑

13.2.1
дэх заалт

385 хүн

30.8
ТЭРБУМ ТӨГРӨГ

13.2.2
дэх заалт

578 хүн

23.1
ТЭРБУМ ТӨГРӨГ

НИЙТ

963
ХҮН

53.9 ТЭРБУМ ТӨГРӨГ

СОЁЛ УРЛАГ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ



ТОКИО-2020 ЗУНЫ ОЛИМП
болон Паралимп-д оролцох
Монгол Улсын **ШИГШЭЭ**
БАГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ЗАРДАЛ

32 | **500**
ТӨРӨЛ | ТАМИРЧИН

20.0 ↑
Тэрбум төгрөг
2019
ОНООС **9.2%**



2020 онд хүүхдийн спортын наадмыг
зохиолн байгуулах зардал

9.6
/Тэрбум төгрөг/



Кино үйлдвэрлэл, дэд бүтцийг сайжруулах
Үндэсний кино контент бүтээх
Олон улсын кино наадам, үзэсгэлэнд
Монгол киног оролцуулах зорилгоор
байгуулагдах **ШИНЭ САН**


10.0
/Тэрбум төгрөг/



Аялал жуулчлалын салбарын дэд бүтцийг
сайжруулах, гадаад сурталчилгаа,
маркетингийн ажлуудыг эрчимжүүлэх,
үйлчилгээний чанарыг сайжруулах, Монгол
Улсад жуулчин хүлээж авах хүчин чадлыг
нэмэгдүүлэх зорилгоор төсвийг нэмэгдүүлсэн

2.0 ↑
Тэрбум төгрөг
2019
ОНООС **8.1%**

**ЖИЛД ИРЖ БУЙ
ЖУУЛЧДЫН ТОО**





05

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР БОЛОН ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖ

- Засгийн газрын өр
- Засгийн газрын гадаад зээл, тусламж

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР



ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН УДИРДЛАГЫН 2019-2022 ОНЫ СТРАТЕГИ

ЗОРИЛТ 1.

Засгийн газрын гадаад, дотоод үнэт цаас, зээлийн төлбөрүүдийг эдийн засаг, төсөвт дарамт учруулахгүйгээр төлж дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулна.

ЗОРИЛТ 2.

Гадаад зээллэгээр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүдэд зардал, үр өгөөжийн тооцооллыг хийж, зөвхөн үр ашигтай төслүүдийг санхүүжүүлэх зарчмыг баримталж, тэдгээрийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулна.

ЗОРИЛТ 3.

Болзошгүй өр төлбөрийн төсөвт үзүүлэх нөлөөллийг үнэлэх, болзошгүй эрсдэлээс сэргийлэх тогтолцоог хөгжүүлнэ.



Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалж, Засгийн газрын санхүүгийн хэрэгцээг боломжит эрсдэлийн түвшинд хамгийн бага зардлаар санхүүжүүлэхэд чиглэнэ.

ЗОРИЛТ 4.


Орчин үеийн технологийн дэвшлийг ашигласан Засгийн газрын үнэт цаасны арилжааны дэд бүтцийг бүрдүүлнэ. Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын арилжаанд оролцох боломжийг нэмэгдүүлж, зах зээлийн нээлттэй, өрсөлдөөнт, хүртээмжтэй байдлыг хангаж, Засгийн газрын үнэт цаасны хөрвөх чадварыг сайжруулна.

ЗОРИЛТ 5.


Засгийн газрын өрийн удирдлагын тогтолцоог сайжруулж, орчин үеийн чиг хандлагад нийцүүлэх.

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР

/Тэрбум төгрөг/



ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ДАРАМТ БУУРЧ БАЙНА




Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээрх үлдэгдэл (ӨҮЦ)/ДНБ харьцааг 2020 оноос ДНБ-ний **70 хувиас** хэтрэхгүй байхаар заасан. Стратегийн баримт бичиг, Төсвийн хүрээний мэдэгдэлд заасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд 2020 онд Засгийн газрын өр ӨҮЦ/ДНБ харьцааг **49.9 хувьд** хүргэж, хуульд заасан шаардлага шалгуур үзүүлэлтийг хангаснаар өрийн тогтвортой байдлыг бүрдүүлнэ.

ИРЭХ ОНУУДАД ТӨЛӨГДӨХ АРИЛЖААНЫ НӨХЦӨЛТЭЙ ТОМООХОН ГАДААД ТӨЛБӨРҮҮД

№	Гадаад бонд	Дүн /сая нэгж/	Купон	Эргэн төлөгдөх огноо
1	Мазаалай	500\$	10.875%	2021.04.06
2	Чингис	1000\$	5.125%	2022.12.05
3	Гэрэгэ	800\$	5.625%	2023.05.01
4	Хуралдай	600\$	8.750%	2024.03.09





ХҮҮГИЙН ЗАРДЛЫН ТӨСӨВТ ҮЗҮҮЛЭХ ДАРАМТ БУУРЧ БАЙНА

Засгийн газрын өрийн хүүгийн зардал 2017 онд төсвийн орлогын **16.4%**, төсвийн зарлагын **13.3%**-ийг эзэлж төсөвт дарамт учруулж байсан бөгөөд шинээр арилжааны нөхцөлтэй гадаад, дотоод зээл авахыг зогсоосноор хүүгийн зардлын төсөвт үзүүлэх дарамт буурч, 2020 онд төсвийн орлогын **10.0%**, төсвийн зарлагын **7.4%**-ийг эзэлж байна.




ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖ

Монгол Улсын хөгжлийг дэмжих зорилгоор гадаад улс, олон улсын байгууллагаас Засгийн газарт буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл олгодог. Ирэх онд улсын төсөвт нийт **115 төслийг 1,296.3 тэрбум** төгрөгийн зээлээр, **40 төслийг 150.3 тэрбум** төгрөгийн тусламжаар санхүүжүүлэхээр төлөвлөлөө.



ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ТОО ХӨГЖЛИЙН ТҮНШ БАЙГУУЛЛАГААР

/Тэрбум төгрөг/



 Зээл

 Тусламж

ОНЦЛОХ ТӨСЛҮҮД



БОЛОВСРОЛ

НИЙСЛЭЛИЙН 3 ДҮҮРЭГТ
5,720 ХҮҮХДИЙН 7
СУРГУУЛЬ

АРХАНГАЙ АЙМАГТ
120 ХҮҮХДИЙН 1 ЦЭЦЭРЛЭГ



ЭРҮҮЛ МЭНД



СОНГИНОХАЙРХАН
ДҮҮРГИЙН ЭМНЭЛЭГ



150 ОРТОЙ “ТҮЛЭНХИЙН
ТӨВ” ЭМНЭЛЭГ



ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЛБАРЫН ХӨГЖИЛ
ХӨТӨЛБӨР



БАЙГАЛЬ ОРЧИН



5,026 АЙЛЫН СОЛОНГО 1, 2
ОРОН СУУЦНЫ ХОРООЛОЛ



2,000 АЙЛЫН БАЯНГОЛЫН
АМ ОРОН СУУЦНЫ
ХОРООЛОЛ



УЛААНБААТАР ХОТЫН ТӨВ
ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖ



1,008 АЙЛЫН ТҮР
СУУРЬШУУЛАХ ОРОН
СУУЦНЫ ХОРООЛОЛ



УЛААНБААТАР ХОТЫН
УС ХАНГАМЖИЙН
НЭМЭГДҮҮЛЭХ МЯНГАНЫ
СОРИЛТЫН САНГИЙН
ТӨСӨЛ



ГАЗРЫН ТОС
БОЛОВСРУУЛАХ
ҮЙЛДВЭР

ADB



АЛТАНБУЛАГ, СҮХБААТАР,
БИЧИГТ, БОРШОО БООМТ,
ХИЛ ОРЧМЫН ДЭД БҮТЭЦ

ADB



ГЭР ХОРООЛЛЫН ДЭД
БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ



УЛААНБААТАР – ДАРХАН
ЧИГЛЭЛИЙН НЭМЭЛТ 2
ЭГНЭЭ АВТО ЗАМ БАРИХ

ADB



УЛААНБААТАР – ДАРХАН
ЧИГЛЭЛИЙН 204.6 КМ АВТО
ЗАМ ЗАСВАРЛАХ



ХӨШИГИЙН ХӨНДИЙН
ОЛОН УЛСЫН НИСЭХ
ОНГОЦНЫ ШИНЭ БУУДАЛ



УЛААНБААТАР –
МАНДАЛГОВЬ ХООРОНД
249 КМ ЦАХИЛГААН
ДАМЖУУЛАХ ШУГАМ БАРИХ
ТӨСӨЛ



ЗАМЫН ЦАГДААГИЙН
УУЛЗВАРЫН ГҮҮРЭН ГАРЦ



ГАЧУУРТ – НАЛАЙХ
ЧИГЛЭЛИЙН 20.9 КМ
АВТО ЗАМ



ADB



ЭРЧИМ ХҮЧ, СЭРГЭЭГДЭХ
ЭРЧИМ ХҮЧИЙГ
НЭМЭГДҮҮЛЭХ



ЗАМЫН-ҮҮД,
ГАШУУНСУХАЙТ БООМТ
(зорчигч тээврийн 30, ачаа
тээврийн 28 барилга, дэд бүтэц)



ӨНДӨРХААН НИСЭХ
ОНГОЦНЫ БУУДЛЫГ
ШИНЭЧЛЭХ






06

ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

- Улс, орон нутгийн төсвийн харилцаа
- Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан

УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХАРИЛЦАА



ОНХНС-ААС СУМДАД ШУУД ХУВААРИЛАХ АШИГТ МАЛТМАЛЫН ЭХ ҮҮСВЭРҮҮД



ХАМГИЙН ӨНДӨР 5 СУМ/НИЙТ/

Аймаг	Сум	(тэрбум төгрөг)
СҮХБААТАР	СҮХБАААТАР	2.2
ӨМНӨГОВЬ	НОЁН	1.6
ДОРНОГОВЬ	ХӨВСГӨЛ	1.4
ӨМНӨГОВЬ	НОЁН	1.2
СЭЛЭНГЭ	ЕРӨӨ	0.8

ХАМГИЙН БАГА 5 СУМ/НИЙТ/

Аймаг	Сум	(сая төгрөг)
БАЯНХОНГОР	ЭРДЭНЭЦОГТ	50.7
СҮХБААТАР	БАРУУН-УРТ	42.8
БУЛГАН	МОГОД	28.4
СЭЛЭНГЭ	БАРУУНБҮРЭН	8.5
ХӨВСГӨЛ	РЕНЧИНЛХҮМБЭ	3.3

/ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын холбогдолтой үйл ажиллагаа явуулаагүй, хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлөөр талбай олгогдоогүй зарим сумдад тус 3 эх үүсвэрийн орлого хуваарилагдаагүй болно/

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН САН 2020 он

/тэрбум төгрөг/





САНГИЙН ЯАМ

